



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 18,293,945.00 (арван найман сая хоёр зуун ерэн гурван мянга есөн зуун дөчин таван) төгрөгийн балансын үнэ, 7,317,577.92 (долоон сая гурван зуун арван долоон мянга таван зуун далан долоон төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота Алфард маркийн 40-45УНП улсын дугаартай автомашиныг "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал О.Баатарцогт, "Биокомбинат" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал М.Энх-Амар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

137005013
18-r_huraldaan.docx